



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/106

Дархан сум

Бэлчээрийн газарт фотомониторинг
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан сумын бэлчээрийн газарт фото мониторинг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	С.Амарболд	- Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Ганболд	- Газрын даамал
Гишүүд:	Ц.Ганбат	- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Мөнхсайхан	- Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Н.Цэрэнжав	- 1 дүгээр багийн Засаг дарга
	Э.Чулуунхүү	- 2 дугаар багийн Засаг дарга
	А.Пунцагдорж	- 3 дугаар багийн Засаг дарга

2."Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх" журам болон "Бэлчээрийн газарт фото мониторинг хийх аргачилсан заавар"-ын дагуу гүйцэтгэн, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Амарболд)-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА  Г.БАТБОЛД

